



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Нийслэлийн газрын албанаас төрийн байгууллагын хэрэгцээнд олгосон газар олголтыг хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэхэд хийсэн эрсдэлийн аудитын тайлан



НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙ БАЙРШИЛД
ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРГАЖ,
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРЭЭР ИРГЭН, АЖ
АХУЙН НЭГЖИД ГАЗАР ОЛГОСОН БАЙНА.



Улаанбаатар 2017

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нийцлийн аудитын
газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор

Б.Алтанзул

Гүйцэтгэлийн аудитын газрын
Аудитор

М.Наранжаргал

Нийслэл дэх Төрийн аудитын
газрын Аудитор

Ч.Түвшинсайхан

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт, хүснэгт, график мэдээллийн эх сурвалж2

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, багийн бүрэлдэхүүн, хугацаа3

Үндсэн мэдээлэл:5

Нэг. Нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны захирамжаар төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх эрх олгохдоо тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын байршлын 71.1 хувийг тусгаагүй байна7

Хоёр. Төрийн байгууллагын хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх эрх олгохдоо дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулах журмыг баримтлаагүй байна9

Гурав. Төрийн байгууллагын эзэмшилд буй газрын эрхийг бусдын нэр дээр шилжүүлсэн, зарим газрыг зориулалтын дагуу ашиглаагүй байна12

Дөрөв. Төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх, газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаж буй байдалд тавих хяналт хангалтгүй байна.....14

Дүгнэлт:15

Зөвлөмж:16

Холбогдох байгууллагын санал:18

Үндэсний аудитын газрын тайлбар:21

Хавсралтууд22

Магадлалын хэмжилт хийсэн ажлын хэсгийн дүгнэлт.....28

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал.....36

2017 оны 6 дугаар сар
Уг тайланг ҮАГ-ын Вэб
сайтаас үзнэ үү.

www.audit.mn

Аудитын тайлан дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261729, 260949
дугаарын утас, факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БХД	Багахангай дүүрэг
ГЗБЕТ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
ГКМС	Газрын кадастрын мэдээллийн сан
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн Газар
НЕТГ	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУХ	Төслийн удирдах хороо
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХСГДХТХ	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгт, график мэдээллийн эх сурвалж

Хүснэгт №1	Нийслэлийн газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлангаас тоон мэдээллийг эх сурвалж болгосон.
График №1	ҮАГ-ын Нийцлийн аудитын газар
График №2	ҮАГ-ын Нийцлийн аудитын газар
Хүснэгт №2	НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 дугаар тогтоолоор баталсан дүн, НЗД-ын 2012-2016 оны хооронд гаргасан захирамжийн дүнг эх сурвалж болгон ҮАГ-ын НАГ-аас дүн шинжилгээ хийв
Хүснэгт №3	НИТХ-ын тогтоолоор тухайн жилийн ГЗБТ-өөр баталсан дүн, НЗД-ын 2012-2016 оны хооронд гаргасан захирамжийн дүнг эх сурвалж болгон ҮАГ-ын НАГ-аас харьцуулсан дүн
Хүснэгт №4	Төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний огноо, НЗД-ын захирамжийн огноог эх сурвалж болгосон.
Хүснэгт №5	ҮАГ-ын Нийцлийн аудитын газар
Хүснэгт №6	ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудит хийсэн үндэслэл:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/145 дугаар албан бичгийг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийлээ.

1.Аудитын нэр: Нийслэлийн газрын албанаас төрийн байгууллагын хэрэгцээнд олгосон газар олголт, хууль тогтоомжийн хэрэгжилт.

2. Аудитын код: YAГ-НАГ/2017/10-ЭА

3. Аудитын зорилт:

Нийслэлийн газрын албанаас төрийн байгууллагын хэрэгцээнд олгосон газар олголт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Төрийн албаны хэрэгцээнд олгосон газар "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-нд тусгагдсан эсэх.
2. Хуульд заасны дагуу дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар газар олгож байгаа эсэх.
3. Олгосон газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх.
4. Газрын олголтод хууль, тогтоомжийн дагуу хяналт тавьж байгаа эсэх.

4. Хамарсан хүрээ:

Аудитад НИТХ-ын Ажлын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Газрын алба, Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Дүүргийн ЗДТГ-ыг хамруулан 2012-2016 оны хооронд төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх эрх олгоходоо холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэхийг авч үзлээ.

Аудитын явцад НЗД-ын 2014 оны А/322, А/543 болон 2015 оны А/933 тоот захирамжаар шийдвэрлэсэн БГД-ийн 18-р хороо орон сууцны 42 байрны дунд 1277 м2, 8-р хорооны 8-р байрны хойд талд 1271 м2, СХД-ийн 17-р хороо орон сууцны 32 байрны дунд 4020м2, 15-р хороо орон сууцны 19 байрны дунд 4070 м2, СБД-ийн 3-р хороо орон сууцны 13-р байрны дунд 912 м2 талбайд газар доорх авто зогсоол барьж байгуулах ажлын төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийг сонгосон эсэх нь тодорхойгүй, холбогдох баримт материалыг НЕТГ, НГА, дүүргийн ЗДТГ ирүүлээгүй тул энэхүү аудитаар асуудлыг нягтлаж үзэх боломжгүй байлаа.

5. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 4000, 4100, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, санхүүгийн болон хяналтын тайланг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалган баталгаажуулав.

6. Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.2.4, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.4, 35.1.6, 35.2 заалт.
- Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 заалт
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.2,15.3 заалт
- Захиргааны Ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйл, 62 дугаар зүйл.
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.ж,19 дүгээр зүйлийн 19.1,
- Хот,суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1.
- УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол
- ЗГ-ын 2006 оны 197 дугаар тогтоол
- ЗГ-ын 2003 оны 28 дугаар “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам” тогтоол
- ЗГ-ын 2010 оны 119 дүгээр “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам” тогтоол /*тухайн үед мөрдөгдөж байсан*/
- ЗГ-ын 2016 оны 10 дугаар “Газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулах журам” тогтоол
- ЗГ-ын 2013 оны 38 дугаар /хуучин/, 2016 оны 79 дугаар /өөрчлөлт орсон/ “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Зам тээвэр барилга хот байгуулалтын Сайдын 2010 оны 206 дугаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал” тушаал
- НИТХТ-ийн 2015 оны 84, 175 дугаар “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам” тогтоол
- НИТХ-ын 2011 оны 8/72 дугаар, 2012 оны 6/26 дугаар, 2013 оны 13/52 дугаар, 2014 оны 21/29 дугаар, 2015 оны 32/32 дугаар, 2015 оны 24/06 дугаар, 137 дугаар, 148 дугаар тогтоолууд
- НЗД-ын 2012 оны А/52, А/153, А/164, А/261, А/332,А/458,А/489 дугаар захирамж,
- НЗД-ын 2013 оны А/04, А/55, А/76, А/173, А/176, А/189, А/197, А/207, А/235, А/242, А/273,А/322,А/351,А/345,А/363,А/391,А/424,А/435, А/453, А/456, А/484, А/492, А/501, А/502,А/566,А/580,А/594,А/607,А/611,А/643,А/738,А/750,А/755,А/811,А/814,А/830,А/83, А/839,А/895,А/899,А/918,А/936,А/992,А/993,А/994, А/1002, А/1015, А/1076, А/1081 дугаар захирамж,
- НЗД-ын 2014 оны А/45,А/55,А/76,А/173,А/175,А/176,А/207,А/228,А/235,А/273,А/322, А/351,А/363,А/502,А/611,А/643,А/664,А/918,А/936,А/992,А/1015, А/1081, Б/175 дугаар захирамж,
- НЗД-ын 2015 оны А/04, А/55, А/453, А/456,А/723,А/750,А/933, А/1002 дугаар захирамж,
- НЗД-ын 2016 оны А/197, А/242, А/284, А/391, А/484, А/501дугаар захирамж.

7.Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, аудит хийсэн хугацаа:

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, Аудитын төлөвлөлтийн үе шатыг 2017 оны 4 дүгээр сарын 3-наас Нийцлийн аудитын газрын аудитор М.Туул, Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитор Ч.Түвшинсайхан нар хийж, гүйцэтгэлийн үе шатыг Ч.Түвшинсайхан 2017 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор М.Наранжаргал нар гүйцэтгэж, аудитыг 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр дуусгав.

Үндсэн мэдээлэл:

НИТХ-аар 2001 онд Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталж, 2010 оны 11 сард “Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг хийсэн байна.

ЗГ-ын 2006 оны 197 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын бүсийн хөгжлийн хөтөлбөрийг, УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг тус тус баталжээ.

Нийслэлийн нутаг дэвсгэр нь нийт 470,444 га талбайг эзэлдэг бөгөөд газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлангаар газар өмчлөгч¹, газар эзэмшигч², бусдын эзэмшиж буй газрыг ашиглагч³, газар ашиглагч⁴ гэж 4 ангилдаг байна.

Нийслэлийн Газрын албаны 2012-2016 онуудын Нийслэлийн газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлангаар төрийн байгууллагын нэрээр газар эзэмших эрх 2012 онд 31.1 хувь, 2013 онд 32.2 хувь, 2014 онд 34.5 хувь, 2015 онд 31.2 хувь, 2016 онд 28.0 хувийг тус тус эзэмшиж байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №1
/өссөн дүнгээр/


А	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч		2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он	
			газар/га/	хувь	газар/га/	хувь	газар/га/	хувь	газар/га/	хувь	газар/га/	хувь
1	эзэмшигч	а/иргэн	13,083.7	25.8	11,685.6	24.0	12,913.9	27.7	14,191.6	27.1	18,334.1	32.9
2		б/төрийн байгууллага	15,775.4	31.1	15,702.6	32.2	16,087.1	34.5	16,328.1	31.2	15,609.1	28.0
3		в/аж ахуйн нэгж	21,867.2	43.1	21,392.9	43.9	17,653.6	37.8	21,852.3	41.7	21,853.9	39.2
		Дүн	50,726.3	100.0	48,781.1	100.0	46,654.6	100.0	52,372.1	100.0	55,797.1	100.0

Эх сурвалж: Нийслэлийн Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан

Мөн Нийслэлийн газрын нэгдмэл сангийн ангилалаар төрийн байгууллагын газар эзэмших эрх Хот тосгон бусад суурины газар 41 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 52 хувь, Зам, шугам сүлжээний газар 3.7 хувь, ойн сан бүхий газар 2.2 хувь, Хөдөө аж ахуйн газар 0.8 хувийг тус тус эзэлж байна. Үүнийг графикаар харуулбал:

/график №1/

/график №2/



Эх сурвалж: Нийслэлийн Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /газрын нэгдмэл сангийн төрлөөр/.

¹ гэр бүлийн хэрэгцээнд, аж ахуйн зориулалтаар

² иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгж

³ иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгж

⁴ гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээд

Төрийн байгууллагын газар эзэмших эрх 2013-2016 оны хооронд өссөн дүнгээр⁵ Хот тосгон бусад суурины газарт 2014-2016 оны хооронд газар шинээр эзэмшүүлэх эрх, газрын ашиглалт нь 4.3-9.1 хувиар нэмэгдэж, 2013 онд 1.2 хувиар буурсан байна.

⁵ 2012 оныг суурь болгов.

Нэг. Нийслэлийн Засаг дарга 2012-2016 оны хооронд төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх эрх олгохдоо тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын байршлын 71.1 хувийг тусгаагүй байна

1.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөгөөг НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 дугаар /2015 оны 24/06, 137, 148 дугаар тогтоолоор 3 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан/ тогтоолоор тус тус баталсан байна.

Нийслэлийн газар зохион байгуулалтын 2012-2016 онуудын төлөвлөгөөнд нийт 740 байршилд 4400.99 га талбайд газар шинээр эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ зориулалтыг тусган баталсан байна./хавсралт №1/ Үүнийг дараах 4 ангиллаар авч үзвэл:

- Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 122 байршилд 1,603.05 га,
- Нийгмийн үйлчилгээний болон олон нийтийн барилга байгууламжид⁶ 284 байршилд 219.54 га,
- Тохижилт бүхий газар доорх авто зогсоолд 38 байршилд 6.91 га,
- Авто зам, замын барилга байгууламжид 296 байршилд 2,571.49 га талбай байна.

1.2. НЗД 2012-2016 онуудад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн 90 удаагийн захирамжаар 613 байршилд 2,624.4 га талбайд газар шинээр эзэмшүүлэх тухай шийдвэрийг гаргасан байна. /хавсралт №2/ Үүнийг дараах 4 ангилалд хуваан авч үзвэл:

- Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 194 байршилд 494.5 га,
- Нийгмийн үйлчилгээний болон олон нийтийн барилга байгууламжийн 146 байршилд 96.4 га,
- Тохижилт бүхий газар доорх авто зогсоол 35 байршилд 5.3 га,
- Авто зам, замын барилга байгууламж 233 байршилд 2,028.2 га талбай байна.

Дээрх 4 ангиллаар 2012-2016 онд баталсан байршлын тоо, талбайн хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт № 2/

Үзүүлэлт	Нийгмийн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж		Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд		Тохижилт бүхий ил болон газар доорх авто гараж		Дэд бүтэц, авто замын чиглэл		нийт дүн	
	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/
НИТХ-ын тогтоолоор ГЗБ-ын баталсан нийт дүн	284	219.5	122	1,603.1	38	6.9	296	2,571.5	740	4,401.0
НЗД-ын захирамжийн дагуу олгосон нийт дүн	146	96.4	199	494.5	35	5.3	233	2,028.2	613	2,624.4
Зөрүү	138	123.2	(77)	1,108.5	3	1.7	63	543.3	127	1,776.6

Эх сурвалж: НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, НЗД-ын 2012-2016 оны захирамжууд.

НИТХ-ын тогтоол “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-өөр баталсан газар эзэмших, ашиглах эрхийг НЗД-ын захирамжаар газар эзэмших эрх олгох тухай /газрын байршил, хэмжээ зориулалтыг/ шийдвэртэй нягтлан үзэхэд төлөвлөгдсөн дүнгийн 127 байршлын 1,776.6 га талбайд газар шинээр эзэмших эрх олгох захирамж гараагүй нь төрийн

⁶ Сургууль, цэцэрлэгийн шинэ болон өргөтгөл хийх барилга, спорт заал, хороо, цагдаагийн цогцолбор, нийгмийн халамж үйлчилгээний зориулалттай

байгууллагаас газар эзэмших хүсэлт гаргаагүй, гаргасан ч тухайн онд эцэслэн шийдвэрлээгүйтэй холбоотой байна.

Нийслэлийн Засаг дарга НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 тогтоолыг зөрчиж 2012-2016 оны хооронд дээрх 4 ангиллын /газрын байршил, талбайн хэмжээ, эзэмшигч, зориулалтаар/ 436 байршилд 1,948.85 га талбайн газрыг шинээр эзэмшүүлэх эрх олгохдоо газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулаагүй нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1⁷-т заасныг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт № 3/

Үзүүлэлт	Газрын байршил		Талбайн хэмжээ		Аудитад хамрагдсан байршлын тоо
	тоо	Хувь	га	Хувь	
НЗД-ын захирамжаар газар эзэмших эрх олгосон дүн	613	-	2,624.39	-	336
НИТХ-ын тогтоолоор баталсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан	177	28.9	675.53	25.7	78
НИТХ-ын тогтоолоор баталсан Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй	436	71.1	1,948.85	74.3	258

Эх сурвалж: НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 дугаар тогтоол, НЗД-ын нийт 90 удаагийн /2012 оны 7 удаа, 2013 оны 49 удаа, 2014 оны 24 удаа, 2015 оны 8 удаа, 2016 оны 6 удаа/ захирамж.

1.3. Аудитад НЗД-ын 2012-2016 оны хооронд “газар шинээр эзэмшүүлэх эрх” болон “газрын зориулалт, талбайн хэмжээ, эзэмшүүлэх эрхэд өөрчлөлт оруулах” зориулалтаар гаргасан нийт 125 удаагийн захирамжаас 336 байршлын 912.96 га талбайн газар олголтын шийдвэрийг түүвэрлэн хамрууллаа.

Үүнээс 2013-2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахгүйгээр НЗД-ын захирамжаар төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээ, тохижилт бүхий авто зогсоол барих зориулалтаар 78 байршлын 93.3 га талбайд шинээр газар эзэмших эрх олгосон байна. /хавсралт №3/ Тухайлбал:

- Тохижилт бүхий газар доорх авто зогсоолын зориулалтаар газар шинээр эзэмшүүлэх эрхийг БГД-ийн 11 байршлын 1.47 га, СБД-ийн 1 байршлын 0.22 га, СХД-ийн 1 байршлын 0.2 га, БЗД-ийн 9 байршлын 1.3 га, нийт 22 байршлын 3.19 га талбай;
- Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан БГД-ийн 20 байршлын 0.26 га, ХУД-ийн 3 байршлын 50.54 га, СБД-ийн 2 байршлын 11.87 га, ЧД-ийн 6 байршлын 11.25 га, СХД-ийн 5 байршлын 1.93 га, БЗД-ийн 4 байршлын 12.05 га, БХД-ийн 1 байршлын 0.1 га, нийт 41 байршилд 88.0 га талбай;
- Нийгмийн үйлчилгээ болон олон нийтийн барилга байгууламжийн чиглэлээр БГД-ийн 2 байршлын 0.0048 га, СБД-ийн 4 байршлын 1.72 га, ЧД-ийн 7 байршлын 0.37 га, БЗД-ийн 2 байршлын 0.02 га, нийт 15 байршилд 2.11 га талбай НЗД-ийн захирамжаар газар шинээр эзэмшүүлэх эрхийг олгохдоо тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.4. Нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газар 2013-2016 оны нийслэлийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа нийслэлийн газрын албатай ажлаа уялдуулаагүйгээс тэдний саналыг төлөвлөгөөнд иж бүрэн тусгаж батлуулаагүй байна.

Мөн НЗД 2013-2016 оны хооронд төрийн байгууллагын хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх шийдвэрийг дур мэдэн олгосон захирамжаас 436 байршил буюу 71.1 хувь нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагаагүй, НИТХ-ын тогтоолыг зөрчсөн байна.

⁷⁷ энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;

Хоёр. Төрийн байгууллагын хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх эрх олгохдоо дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулах журмыг баримтлаагүй байна

2.1.НЗД-ын 2014-2015 оны 8 удаагийн захирамжаар 35 байршлын 5.26 га талбайд тохижилт бүхий авто зогсоол барьж байгуулахаар Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3⁸, 21.2.4⁹, 33 дугаар зүйлийн 33.1.1¹⁰ дэх заалт, НИТХТ-ийн 2015 оны 84,175 тоот тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам”-ыг үндэслэн газар шинээр эзэмшүүлэх эрхийг төрийн байгууллагад олгохоор шийдвэрлэсэн байна.

НЗД-ын 2014 оны А/322 дугаар захирамж “Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт бүхий автомашины газар доорх зогсоол байгуулах”-аар БГД, СХД, ХУД, БЗД, СБД-ын 7 байршилд 13859 м2 талбайд газар эзэмшүүлэх, гэрээ байгуулж, гэрчилгээ олгох эрхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хариуцуулсан байсныг 2014 оны А/543 дугаар захирамжаар дүүргүүдийн ЗДТГ-т эрхийг шилжүүлэхээр өөрчлөлт оруулсан байна.

2.2. НЗД-ын 2014 оны 4 дүгээр сард А/322 дугаар захирамжаар 2 байршлын 0.22 га талбайд газар доорх авто зогсоол байгуулах шийдвэр гарсан байхад дор дурьдсан нэр бүхий иргэдтэй 2013 оны 8 дугаар сард Хамтран ажиллах гэрээг байгуулсан нь газар шинээр эзэмшүүлэх эрх олгосон шийдвэрийн хугацаатай зөрчилдөж байна. Хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт № 4/

№	Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Захирамжийн огноо, дугаар	Хамтран ажиллах гэрээ хийсэн огноо, дугаар	Байршил	Зориулалт	Хэмжээ /м2/	тайлбар
1	Иргэн Ё.Раднаасүрэн	2014 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/322 дугаар, 2014.06.30-ны өдрийн А/543	2013.8.01-ны өдөр /дугаар байхгүй/	Баянзүрх дүүргийн 15-р хороо 6 дугаар байрны урд талд	Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт бүхий автомашины газар доорх зогсоол	1280	Төслийг санаачлагч УБ хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Б.Бадрал, төсөл хэрэгжүүлэгч иргэн Ёлхорсүрэн овогтой Раднаасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч Э.Бат-Үүл баталсан.
2	Иргэн Н.Мягмаржав	2014 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/322 дугаар, 2014.06.30-ны өдрийн А/543	2013.8.12-ны өдөр 13/06-4 дугаартай.	Баянзүрх дүүргийн 7-р хороо 2 дугаар байрны зүүн талд талд	Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт бүхий автомашины газар доорх зогсоол	900	Төслийг санаачлагч УБ хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Б.Бадрал, төсөл хэрэгжүүлэгч иргэн Нарантуяа овогтой Мягмаржав, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч Э.Бат-Үүл баталсан.

Эх сурвалж: НЗД-ын 2014 оны А/322, А/543 дугаар захирамж, 2013 оны 8 дугаар сарын 1-ны өдрийн “Хамтран ажиллах гэрээ”, 2013 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 13/06-4 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”.

2.3. НИТХТ-ийн 2015 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам”-ын 6.2 “Авто зогсоолын барилга байгууламжийг зориулалтын дагуу барьж, ашиглалтад оруулж, комиссын акт баталгаажсаны дараа газар эзэмших эрхийг төсөл хэрэгжүүлэгчид шилжүүлж, төсөл хэрэгжүүлэгч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулна” гэж заасан нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалттай зөрчилдсөн бөгөөд журам

⁸Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу хотын суурьшлын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд холбогдох дүүргийн Засаг даргын саналыг авсан байна

⁹ Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл болон тухайн жилийн газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу энэ хуулийн 21.2.3-т заасан газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах.

¹⁰ “энэ хуулийн 29.1, 29.2, 29.3 -т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;”

бүхэлдээ ЗГ-ын 2010 оны 119 дүгээр “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 1.3¹¹, 1.4¹², 1.7.1¹³ заалттай нийцээгүй, хуулиас давсан зохицуулалттай байна.

2.4. НЗД-ын 2014 оны А/811 дугаар захирамж “БЗД-ийн 7-р хороо дээрээ иж бүрэн тохижилт бүхий хүүхдийн тоглоомын талбайтай газар доорх автомашины гаражийн зориулалтаар 2287 м² талбайг”-аар тус дүүргийн ЗДТГ-т 5 жилийн хугацаатай газар эзэмшүүлэх¹⁴ шийдвэрийг НЗД-ын 2016 оны А/561 дугаар захирамжаар хүчингүй болгож, уг байршилд газар эзэмшүүлэх эрхийг иргэн Бээлийнхэн овогт Сундуйгийн Чулуунбат /регистр: ШД66011609/-т олгохоор шийдвэрлэсэн, төсөл хэрэгжүүлэгч иргэнийг хэрхэн сонгосон талаар тодорхойгүй байгаа нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2¹⁵, 33 дугаар зүйлийн 33.1.2¹⁶, ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Дээрх захирамжаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-үүл Газрын тухайн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасныг зөрчиж төрийн байгууллагын нэр дээрх газар эзэмших эрхийг иргэний нэр дээр шилжүүлсэн байх тул хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлэх нь зүйтэй байна.

2.5. НЗД 2012-2016 оны хооронд 27 удаагийн захирамж гаргаж, төсөвт байгууллагын¹⁷ зайлшгүй хэрэгцээ гэсэн ангилалд багтаан 39 байршлын 277.6 га газрыг 11 ТӨХК, 27 ОНӨААТҮГ, 1 УТҮГ-т /хавсралт №4/ газар шинээр эзэмшүүлэх эрх олгохоор шийдвэрлэсэн нь ЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-тай нийцээгүй байна. Дээрх газар олголтыг зориулалтаар хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт№5/

Газар олголтын зориулалт	Байршил	Хэмжээ /га/
Дахин дамжуулах болон дэд станц	9	1.98
Ус усан хангамжийн зориулалтаар	21	128.67
Авто худалдаа	5	143.32
Албан контор болон үйлчилгээ	4	3.59
НИЙТ ДҮН	39	277.57

Эх сурвалж: НЗД-ын 2013 оны А/345, А/424, А/425, А/471, А/547, А/755, А/830, А/895, А/1010, 2014 оны А/76, А/235, А/363, А/351, А/1015, 2015 оны А/04, А/245, А/275, А/465, А/466, А/469, А/702, А/822, А/861, А/1002, 2016 оны А/208, А/242, А/334 дугаар захирамж.

2.6. Тохижилт бүхий газар доорх авто зогсоолыг барьж байгуулах 32 байршлын 4.91 га талбай бүхий газарт төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийг этгээдийг сонгохдоо Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, ЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан¹⁸ журмыг мөрдөөгүй байна.

¹¹ Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргана.

¹² Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэхгүй бөгөөд ийм шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй,

¹³ Үндсэн хууль болон бусад хууль, МУ-ын олон улсын гэрээ, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын шийдвэрт нийцсэн байх;

¹⁴ Төрийн байгууллагын газар эзэмших эрх /дугаар 000437387, нэгж, талбарын 133011/0149 дугаар бүхий/-ийн гэрчилгээг Баянзүрх дүүргийн ЗДТГ-т /НЗД-ын 2014.09.23-ны өдрийн А/811 тоот шийдвэрийг үндэслэн/ Баянзүрх дүүргийн 7-р хороонд дээрээ иж бүрэн тохижилт бүхий хүүхдийн тоглоомын талбайтай газар доорх автомашины гаражийн зориулалтаар 2287 м² газрыг 5 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр 2014.09.23-ны өдөр гэрчилгээг олгосон.

¹⁵ 35.2. Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй.

¹⁶ “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.”

¹⁷ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34. “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

¹⁸ “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах”

Дээрх байдалд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 206 дугаар тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-аар баталсан журмын дагуу дуудлага худалдаа явуулах доод үнэ буюу суурь үнээр тооцож үзэхэд төсөвт ойролцоогоор 1,435.1 сая төгрөгийг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Нийслэлд хэрэгжиж буй тохижилт бүхий газар доорх авто зогсоолыг барьж байгуулах зарим ажил архитектур төлөвлөлтийн даалгаваргүй, эскиз зураггүй, иргэдийн маргаантай зэрэг шалтгаанаар 9 байршилд “Хамтран ажиллах гэрээ” байгуулаагүй, “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан ч 13 байршилд ажил эхлүүлээгүй байна.

Гурав. Төрийн байгууллагын эзэмшилд буй газрын эрхийг бусдын нэр дээр шилжүүлсэн, зарим газрыг зориулалтын дагуу ашиглаагүй байна

3.1.Аудитаар түүвэрлэн авсан 27 байршлын 1007.8 га талбайг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг үзэхэд 5 байршлын 10.0 га газрын эзэмшил нь газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэлтэй зөрүүтэй, 2 байршлын 0.8 га газар бусад газрын эзэмшилтэй давхацсан, 8 байршлын 979.3 га газрыг зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь газар зохион байгуулагчид нэгж талбарын хувийн хэргийг цаг хугацаанд нь бүрдүүлээгүй, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс газрын эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавиагүйтэй холбоотой байна.

Газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээллийн зөрүүтэй байдлыг дурьдвал:

- Барилгын политехник коллежийн сургалтын зориулалттай 1.6 га, ОСНААУГ-ын баруун түгээх төвийн сургалт, оношилгоо, конторын зориулалттай 0.35 га, МИАТ ТӨХК-ны эзэмшлийн 6 га, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын эдэлбэр 1.25 га, Монгол зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын дээд сургуулийн сургалт, дотуур байр, ажилчдын орон сууцны зориулалтаар 1.4 га газруудын барьсан хашаа ГКМС-ийн зургаас зөрүүтэй;
- СХД-ийн Эрүүл мэндийн төв, амбулатори 1-ийн 0.8 га эзэмшлийн газар дээр нийслэлийн түргэн тусламжийн төвийн барилга баригдсан боловч газрын албаны мэдээллийн санд бүртгээгүй;

Зарим газрын хэмжээ бусад газрын эзэмшилтэй давхацсан байдлыг дурьдвал:


- БЗД дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн албан конторын зориулалттай 0.5 га талбай боловч эдэлбэр газрын зарим хэсэг хажуу талын иргэн Баяраагийн орон сууцны газартай давхацсан;
- ЧД-т байрлах Нийслэлийн тээврийн газрын үйлчилгээний зориулалттай 0.27 га газрын ойролцоох барилгуудын зарим хэсэг кадастрын зурагт давхацсан, хашаа нь дотогшоо татагдсан байна.
- Ган зам 20 дугаар сургуулийн сургалтын зориулалттай 1.6 га эдэлбэр газар дээр NEW ERA үндэсний лаборатор сургуулийн барилга баригдсан, сургуулийн урд хэсгээр ТҮЦ хашааны цэгтэй давхацсан,

Эзэмших газрыг зориулалтын дагуу ашиглаагүй байдлыг дурьдвал:

- БГД-ийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 0.1 га газар “Ган морит бор” ХХК-ны, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн НӨТҮГ-т цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалтаар олгосон 973.3 га газрын хойд хэсгээр “Шинэ зуун айл зах” ХХК-ны хатгасан хашаанд орсон,
- Ерөнхий боловсролын 87 дугаар сургуулийн сургалтын зориулалттай 1.45 га газарт мэдээллийн санд бүртгэгдээгүй багш ажилчдын 2 давхар 8 айлын орон сууц баригдсан,
- 99 дүгээр цэцэрлэг 0.9 га газрын урд талын хэсгийг тусгаарлан хашаалж дотор нь барилгын нүх ухсан,
- Нийслэлийн боловсролын газарт СХД-т олгосон 1 га газарт, Нийслэлийн ЗДТГ-ын ХУД-т орчны тохижилт бүхий олон давхар гаражийн зориулалттай олгосон 0.14 га газарт тус тус айл зөвшөөрөлгүй хашаа хатган буусан.
- СХД-т байршилтай ОСНААУГ-ын баруун түгээх төвийн /хуучин нэрээр Өнөр Энх Өргөө ОНӨААТҮГ/ газар нь 3500 м.кв талбайтай газар эзэмших эрхтэй бүртгэгдсэн байна. Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр одоо эзэмшиж буй газар нь 2336.4 м² талбайтай гарсан бөгөөд 1163.6 м² талбайг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Мөн ажлын хэсгийн магадлан хэмжилт хийсэн А/125 дүгнэлтээр БГД-т байршилтай Ган зам 20 дугаар сургууль НЗД-ын 2016 оны А/128 тоот захирамжаар 16366 м² талбайтайгаар бүртгэгдсэнийг газрын кадастрын мэдээллийн сантай давхцуулж үзэхэд “Шинэ эрин” дунд сургуульд 1453 м² газарт барилга, 717 м² газрыг “биеийн тамирын талбай”-н зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглуулж байна.

Кадастрын зураг



Бодит байдал



3.2.НЗД 2013-2016 оны хооронд 81 удаагийн захирамжаар төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгосон газраас хэсэгчлэн 119 байршлын 102.29 га талбайг амины болон орон сууц, 4 байршлын 2.5 га талбайг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар нийт 123 иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

/хүснэгт№6/

№	Зориулалт	Иргэн		Аж ахуй нэгж	
		байршил	талбай /га/	байршил	талбай /га/
1	Амины орон сууц	39	2	1	40.00
2	Контор			1	0.44
4	Орон сууц	41	2	38	57.66
6	Үйлдвэрлэл			2	2.00
7	үйлчилгээ			1	0.06
НИЙТ ДҮН		80	5	43	100.16

Эх сурвалж: НЗД-ын 2012 оны А/52, А/164, А/261, А/458, А/489, 2013 оны А/752, А/1050, А/416, А/191, А/978, А/752, А/855, А/978, А/838, А/582, А/1081, А/830, А/1053, А/607, 2014 оны А/205, А/233, А/812, А/349, А/386, А/812, А/502, А/947, 2015 оны А/452, А/1000, А/53, А/937, А/979, А/822, 2016 оны А/444, А/247,

Дээрх 81 удаагийн захирамжаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-үүл Газрын тухайн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасныг зөрчиж төрийн байгууллагын нэр дээрх газар эзэмших эрхийг иргэн, хуулийн этгээдийн нэр дээр шилжүүлсэн байх тул хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлэх нь зүйтэй байна.

Дөрөв.Төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар шинээр эзэмшүүлэх, газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаж буй байдалд тавих хяналт хангалтгүй байна.

4.1.Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2012-2016 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газарт дотоод хяналт шалгалт хийсэн боловч газрын албаны үйл ажиллагаа, газар олголт, түүний ашиглалтын байдалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, НӨХГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс нь тодорхой ажил зохион байгуулаагүйгээс дээрх зөрчил дутагдал гарах нөхцөл бүрдсэн байна.

4.2.НЗД Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай урьдчилан зөвшилцөөгүй, НИТХ-ийн шийдвэр гараагүй байхад 32 төрийн байгууллагын нэр дээрх 89 байршлын 236.5 га талбай бүхий газар эзэмших эрхэд эрх шилжүүлэх өөрчлөлт оруулахаар захирамжилсан нь Засгийн Газрын 2013 оны 38 дугаар “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 6¹⁹ заалтыг */энэхүү заалтад ЗГ-ын 2016 оны 79 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/* мөрдөөгүй байна. */Хавсралт №6/*

4.3.Аудитын явцад Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсэгтэй хамтран 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 28-ны хооронд БЗД, БГД, СХД, ЧД-ийг хамруулан нийт 27 байршилд хэмжилт хийхэд 7 байршлын 1.37 га нь талбай бусад газрын эзэмшилтэй давхцалтай */ажлын хэсгийн А/125 тоот дүгнэлт/* байна. Давхацсан газрын дүгнэлтийг хавсралтаар оруулав. */Хавсралт №7/*

¹⁹ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүрт Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай урьдчилан зөвшилцөж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулахдаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн газрын албаны ажлын уялдаа хангалтгүй, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иж бүрэн боловсруулаагүй, Нийслэлийн Засаг дарга дур мэдэн газар шинээр эзэмшүүлэх эрх олгосон захирамжаар 436 байршил буюу 71.1 хувь нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, НИТХ-ын 2011 оны 8/72, 2012 оны 6/26, 2013 оны 13/52, 2014 оны 21/29, 2015 оны 32/32 дугаар тогтоол, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-т заасныг тус тус зөрчсөн байна.
2. НИТХТ-ийн 2015 оны 175 дугаар тогтоолоор баталсан *“Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам”* нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 35 дугаар зүйлийн 35.2-т заасныг тус тус зөрчсөн, Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан *“Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”*-тай нийцээгүй, эрхээ хэтрүүлэн хуулиас давсан шийдвэр гаргасан байна.
3. Нийслэлд хэрэгжиж буй тохижилт бүхий газар доорх авто зогсоол барьж байгуулах 9 байршилд *“Хамтран ажиллах гэрээ”* байгуулаагүй, *“Хамтран ажиллах гэрээ”* байгуулсан ч 13 байршилд ажил эхлүүлээгүй байна.
4. Нийслэлийн Засаг дарга 39 байршлын 277.6 га газрыг улсын болон орон нутгийн өмчит байгууллагад шинээр эзэмшүүлэх эрх олгоходоо төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд гэж шийдвэр гаргасан нь Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан *“Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”*, *“Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”*-тай нийцэхгүй байна.
5. Нийслэлийн Засаг дарга захирамж гарган төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгосон газраас хэсэгчлэн орон сууцны, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлж Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасныг зөрчсөн байна.
6. Нийслэлийн Засаг дарга 89 байршлын 236.5 га талбай бүхий зарим төрийн байгууллагын нэр дээрх газрын эзэмших эрхэд өөрчлөлт оруулахдаа холбогдох байгууллагын зөвшөөрөл, шийдвэрийг үндэслээгүй захирамжилсан нь Засгийн Газрын 2013 оны 38 дугаар *“Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” /ЗГ-ын 2016 оны 79 дугаар тогтоолоор 6 дугаар заалтад өөрчлөлт орсон/* тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.
7. Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл зөрүүтэй, газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, бусдын эзэмшил газартай давхацсан зэрэг зөрчил нь газар зохион байгуулагчид нэгж талбарын хувийн хэргийг цаг хугацаанд нь бүрдүүлээгүй, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс газрын эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавиагүй, дотоод хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Нийслэлийн ИТХ-ын даргад:

1. НИТХТ-ийн 2015 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам” нь хуулиас давсан зохицуулалттай тул хүчингүй болгох;
2. Газрын талаарх хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох, цаашид газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж ажиллах.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:

1. Нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар эзэмшигч, газрын байршил, зориулалт, талбай хэмжээ нь тодорхой, газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдсан газарт газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг гаргаж, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.2.4 заалтыг мөрдөж ажиллах;
2. “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх, барьж байгуулах журам”-ыг үндэслэн иргэнд олгосон газар эзэмших эрхийг хүчингүй болгох;
3. Нийслэлийн хэмжээнд төрийн болон төсвийн байгууллагын зайлшгүй хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх эрх олгох, өөрчлөлт хийх тухай бүрт Газрын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн, Засгийн Газрын 2016 оны 10 дугаар, 2013 оны 79 дугаар тогтоолоор баталсан журмыг баримтлан хэрэгжүүлж ажиллах;
4. Нийслэлийн газрын албаны кадастрын мэдээллийн сангийн мэдээллийн иж бүрэн байдал, газар олголт, түүний эзэмшил, ашиглалтын байдалд дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож Үндэсний Аудитын Газарт эргэж мэдэгдэх;
5. Цаашид аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байх, ажлын хариуцлага алдсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож байх.

Нийслэлийн Газрын албаны даргад:

1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иж бүрэн боловсруулж батлуулах, НИТХ-ын тогтоолыг мөрдөж ажиллах;
2. Тохижилт бүхий газар доорх авто зогсоолын ажил нь дууссан 6 байршлын 10320 м² талбайд газрын суурь үнийг тогтоож, газар эзэмшүүлэх эрхийг Газрын тухай хууль болон Засгийн Газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг баримтлан шийдвэрлэх;

3. Магадлан хэмжилт хийсэн ажлын хэсгийн дүгнэлтээр гарсан газрын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэлтэй зөрүүтэй, бусад газрын эзэмшилтэй давхацсан, газрыг зориулалтын дагуу ашиглаагүй зөрчлүүдийг арилгах талаар тодорхой ажлыг зохион байгуулах, хяналтыг сайжруулах.

Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын даргад:

1. Нийслэлд хэрэгжиж буй тохижилт бүхий ил болон газар доорх авто зогсоолыг барьж байгуулах “Хамтран ажиллах гэрээ” байгуулаагүй, ажил эхлүүлээгүй байршилд төсөл хэрэгжүүлэгчдийг Газрын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ыг баримтлан шийдвэрлэх.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргад:

1. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1...”...болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг...”-т заасныг хэрэгжүүлэхэд ойлгомжтой, тодорхой байх зайлшгүй шаардлагатай тул хууль, тогтоомжийг боловсронгуй болгох саналыг дээд шатны байгууллагад уламжлах.

Холбогдох байгууллагын санал:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц.Жигжиджавын гудамж-7/1, Хангарди ордон
Утас: 32-04-61, Факс: (976-11) 32-18-08
<http://www.mpa.ub.gov.mn>

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2017.05.10. № 01/1578.

Танай _____ -ны № _____ -г

Тайлбар хүргүүлэх тухай

Танай газраас "Нийслэлд хэрэгжсэн зарим төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын тайлан"-д тус газраас дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам" нь Захиргааны ерөнхий хууль хэрэгжихээс өмнө батлагдсан бөгөөд уг журмыг боловсруулж батлуулж байх үед Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам" мөрдөгдөж байсан. Уг журам нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлагдсан бөгөөд журмыг бүртгүүлэх ажлыг зөвлөмжид дурьдсаны дагуу Хурлын ажлын албанаас зохион байгуулж ажиллах нь зүйтэй байсан.

2. Нийслэлийн Засаг даргын 2013-2016 үйл ажиллагааны хөтөлбөрт авто зогсоолыг нэмэгдүүлэх талаар зааж, мөн авто зогсоолыг нэмэгдүүлж, иргэдэд амьдрах ая тухтай орчныг бий болгох шаардлага байсан тул журмын дагуу тухайн дүүргийн Засаг дарга төсөл хэрэгжүүлэгчтэй "Хамтран ажиллах гэрээ" байгуулан Баянзүрх дүүргийн 5 байршил, Сүхбаатар дүүрэгт 1 байршилд хамтран ажиллах гэрээ байгуулж, Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан эх загвар зураг баталсан.

3. Аудитын тайлангийн хүснэгт 11 дугаарт заагдсан газар доорх авто зогсоол байгуулах төсөл хэрэгжүүлж байгаа иргэн Ч.Энхцэцэг нь холбогдох журмын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Иргэн С.Чулуунбатын авто зогсоол нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 65 дугаар шийдвэрээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулсан хэмээн шүүх дүгнэсэн. Иргэн Д.Батмөнх, Ч.Эрдэнэцэцэг нарын авто зогсоолын асуудал нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд захиргааны хэрэг үүсч хэрэг хянан хэлэлцэгдэж байгаа бөгөөд холбогдох баримт бичиг болон хувийн хэргийг шүүхэд эх хувиар актаар хүлээлгэж өгсөн болно.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 65 дугаар шийдвэр 7 хуудас, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд архивын баримт хүлээлгэн өгсөн акт 2 хуудас тус тус хавсралтаар хүргүүлж байна.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
БӨГӨӨД ГАЗРЫН ДАРГА



1150501419



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-7/1
Утас/Факс: (976-11) 31-57-11
E-mail: cityland@gazar.ub.gov.mn
<http://www.gazar.ub.gov.mn>

2017.05.11 № 05/1842
танай _____-ны № _____-т

Г МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ Г
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас "Нийслэлд хэрэгжсэн зарим төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тус албанд ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаж, саналыг хавсралтаар хүргүүлэв.

ДАРГА



Э.Б.БОЛОРЧУЛУУН

115050002742

Нийслэлийн Газрын албаны 2017
оны 05 дугаар сарын 11-ний өдрийн
05/11/17-д тоот албан бичгийн хавсралт

**Нийцлийн аудитын тайлангийн
төслийн санал, тайлбар
/ҮАГ-НАГ/2017/10-ЭА/**

1. Тайлангийн төслийн 4.1, 6,7 дугаар хуудас. Нийслэлийн тухайн жилийн Газар зохион байгуулалтын 2013, 2014, 2015, 2016 онуудын төлөвлөгөөг тухайн үеийн чиг үүргийн дагуу Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар /тухайн үеийн нэрээр/ боловсруулж, батлуулж байсан. Монгол Улсын Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 /Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт газрын асуудал эрхэлсэн алба, сумд газрын даамалтай байна./, 23 дугаар зүйлийн 23.3.5 /нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлыг зохион байгуулах/-д заасны дагуу Нийслэлийн Газрын асуудал эрхэлсэн алба мэргэжлийн байгууллагын хувьд Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төслийг иж бүрэн, оновчтой боловсруулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг нэг байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулаагүй нь ийнхүү дүгнэлт гаргахад хүрсэн гэж үзэж байна.
2. Тайлангийн төслийн 4.2, 10 дугаар хуудас. Тайлангийн төсөлд ТӨХК, ОНӨААТҮГ, УТҮГ-ууд нь төсөвт болон төрийн бус байгууллага гэж үзэх үндэслэлийг тодорхой тайлбарлаагүй байна. Мөн тус албаны зүгээс аудитын шалгалттай холбогдуулан шаардагдсан материал, тайлбар, мэдээллийг байгууллагын архивын баримт, мэдээллийн сангийн хүрээнд бүрэн гарган өгч ажилласан. Тохижилт бүхий газар доорх гаражийн газар эзэмших эрх олгосон болон уг газруудад хийгдсэн хамтран ажиллах гэрээ, түүнтэй холбоотой бусад материалууд тус албанд бүрдээгүй, холбогдох байгууллагад хандаж гаргуулах талаар мэдэгдсэн. Иймд тус албаны зүгээс энэ асуудлыг нягтлан үзэж боломжийг хязгаарлаагүй болно.
3. Тайлангийн төслийн 4.3, 11 дүгээр хуудас. “Эзэмших газрыг зориулалтын дагуу ашиглаагүй” хэсэгт ТҮЦ, хашааны цэг, “Ган морьт бор” ХХК, “Шинэ зуун айл зах” ХХК-ны хашаа зэрэг зөвшөөрөлгүй баригдсан хашаа, байрлуулсан байгууламжуудтай давхацсан гэж дурьдсан нь ямар үр дүнг харуулахыг зорьсон нь тодорхойгүй байна.
4. Тайлангийн төслийн зөвлөмжийн тус албанд зөвлөсөн хэсэгт. Тохижилт бүхий газар доорх гаражийн төсөл хэрэгжүүлэгчид ажил нь дууссаны дагуу газрын дуудлага худалдааны анхны үнийг ямар үндэслэлээр нөхөн төлүүлэхийг дурдаагүй /тухайн газрууд нь төрийн байгууллагын эзэмшилд байгаа/, нөхөн төлүүлсний дараа газар эзэмшүүлэх шийдвэр гаргахад Газрын тухай хуулийн 35.2 дахь хэсэгт зөрчилдөх эсэх, энэ асуудлыг хэрхэн зохицуулах талаар тусгуулах зэрэг болно.

Үндэсний аудитын газрын тайлбар:

1. Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас ирүүлсэн 3 заалт бүхий тайлбар нь зарчмын зөрүүгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй;
2. Нийслэлийн Газрын албанаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 05/1847 тоот албан бичгээр 4 заалт бүхий санал ирүүлснийг судлан үзэж 1 дэх санал тайланд дурьдсан зөрчлийг хүлээн зөвшөөрсөн, 2, 3 дах санал зарчмын зөрүүгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй, 4 дэх заалт бүхий саналыг хүлээн авч Нийслэлийн Газрын албаны даргад өгсөн 2 дах зөвлөмжид найруулгын өөрчлөлт хийлээ.
3. ҮАГ-аас 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 2/893 дугаар албан бичгээр Нийслэлийн газрын албанд хүргүүлсэн тайлангийн төсөлд аудитын чанарын баталгаажуулалт хийх явцад дугаарлалтад өөрчлөлт орж, тайлангийн төсөлд бичигдсэн зөрчил нь 4.Хамрах хүрээ. 4 хуудас, тайлангийн 3.1. 11 хуудаст тус тус хэвээр байгаа болно.

Нийслэлийн Газрын албаны даргад:

4. Тохижилт бүхий газар доорх авто зогсоолын ажил нь дууссан 6 байршлын 10320 м² талбайд газрын суурь үнийг тогтоож, газар эзэмшүүлэх эрхийг Газрын тухай хууль болон Засгийн Газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг баримтлан шийдвэрлэх.

Хавсралтууд

НИТХ-ын тогтоолоор 2012-2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр баталсан газрын байршлын тоо, талбайн хэмжээний нэгтгэл

Хавсралт №1

ГЗБТ-ний он	Нийгмийн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж		Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд		Тохижилт бүхий ил болон газар доорх авто зогсоол		Авто зам, замын барилга байгууламж		нийт дүн	
	байршлын тоо	талбай /га/	байршлын тоо	талбай /га/	байршлын тоо	талбай /га/	байршлын тоо	талбай /га/	байршлын тоо	талбай /га/
2012 он	119	58.05	27	123.14	12	2.35	53	152.63	211	336.17
2013 он	83	53.98	4	6.50	0	-	53	1,345.64	140	1,406.12
2014 он	34	29.73	23	19.99			30	129.80	87	179.52
2015 он	3	0.19	59	92.02	0	-	37	463.48	99	555.69
2016 он	45	77.59	9	1,361.40	26	4.56	123	479.94	203	1,923.49
2012-2016 оны нийт дүн	284	219.54	122	1,603.05	38	6.91	296	2,571.49	740	4,400.99

НЗД-ын захирамжаар 2012-2016 оны хооронд газар шинээр эзэмшүүлэх эрх олгосон газрын байршлын тоо, талбайн хэмжээний нэгтгэл

Хавсралт №2

ГЗБТ-ний он	Нийгмийн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламжийн чиглэл		Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд		Тохижилт бүхий ил болон газар доорх авто граж		Авто зам, замын барилга байгууламж		нийт дүн	
	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/	байршлын тоо	талбайн хэмжээ /га/
2012 он	60	18.8	56	53.3			61	688.8	177	760.9
2013 он	47	27.1	65	327.3			69	238.0	181	592.3
2014 он	27	21.6	62	98.0	9	1.7	100	1,096.9	198	1,218.4
2015 он	12	28.9	7	11.4	23	2.9	2	0.4	44	43.6
2016 он			9	4.5	3	0.6	1	4.1	13	9.2
2012-2016 оны нийт дүн	146	96.4	199	494.5	35	5.3	233	2,028.2	613	2,624.4

Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгосон газраас ГЗБТ-д тусгаагүй байршлын нэгтгэл /дүүргээр/.

Хавсралт №3

Огноо	БГД		ХУД		БЗД		СХД		СБД		ЧД		БХД		НИЙТ ДҮН	
	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/	Байршлын тоо	Хэмжээ /га/
2012															0	-
2013	2	0.1542			3	11.8			3	11.629	3	10.08	1	0.1	12	33.76
2014	20	0.1063	3	50.54	4	0.3768	5	1.9289	2	0.262	7	0.666			41	53.88
2015	11	1.4698			5	0.5391	1	0.201	1	0.216	2	0.8206			20	3.25
2016					3	0.66			1	1.7	1	0.0511			5	2.41
НИЙТ ДҮН	33	1.7303	3	50.54	15	13.376	6	2.1299	7	13.807	13	11.618	1	0.1	78	93.30

Төсөл сонгон шалгаруулалтгүйгээр газар шинээр олгосон нэгтгэл

Хавсралт №4

Газар олголтын зориулалт	Байршил	Хэмжээ /га/	ГЗБТ туссан эсэх			
			Туссан		Тусаагүй	
			Байршил	Хэмжээ /га/	Байршил	Хэмжээ /га/
Дахин дамжуулах болон дэд станц	9	1.98	2	1.44	7	0.54
Ус усан хангамжийн зориулалтаар	21	128.67	3	0.47	18	128.20
Авто худалдаа	5	143.32	5	143.32	0	
Албан контор болон үйлчилгээ	4	3.59	3	3.28	1	0.32
НИЙТ ДҮН	39	277.57	13	148.52	26	129.05

Төрийн байгууллагын эзэмшилд буй газрыг иргэн, аж ахуйн нэгж, ТББ-ийн нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлсэн жагсаалт

Хавсралт №5

№	Газар эзэмшигчийн нэр	Газрын байршил /хороо/	Байршил тоо	Зориулалт	Хэмжээ /га/	Өмнөх эзэмшигч, ашиглагч	Хугацаа / жил /	Захирамж огноо, дугаар
1	26 дугаар сургууль	13	1	Ажилчдын орон сууц	0.12	Компани ТББ	15	НЗД-ын 2013 оны А/830
2	Батлан хамгаалах яам	БЗД-4	1	Орон сууц	0.16	Компани ТББ	5	2012.04.18
3	БГДЗДТГ	БГД 5 хороо	3	Ажилчдын орон сууц	0.292	Компани ТББ	5	НЗД-ын 2012 оны А/489
4	БГД Цагдаагийн 1-р хэлтэс	БГД-н 02 хороо	1	Контор, орон сууц	0.066	Компани ТББ	5	2014.11.13
5	БЗД Цагдаагийн 2-р хэлтэс	4	1	Ажилчдын орон сууц	0.099	Таван сүлдэт эрдэнэ нөхөрлөл	7 жил 7 сар	НЗД-ын 2016 оны А/444
6	Гадаад харилцааны яам	19	1	Ажилчдын зуслан	11.64	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/1081
7	ГХЯам	4	1	Орон сууц	1.08	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/830
8	ДХИС	БЗД-8	1	сургалт, орон сууц	0.09	Компани ТББ	5	2012.07.05
9	Замын-Үүд гаалийн газарт	БЗД-25	1	Орон сууц	0.15	Компани ТББ	5	2012.07.05
10	2 дугаар нэгдсэн эмнэлэг	3	4	Орон сууц, контор	1.8	Чинбулаг ХХК	3	НЗД-ын 2014 оны А/233, А/812
11	МУЭХолбоо	7	2	Үйлчилгээтэй, орон сууц	0.34	Блюдрагон ХХК	5	НЗД-ын 2013 оны А/416
12	МҮОНРТ	11	2	Орон сууц	0.37	Компани ТББ	5	2014.11.12
13	НХХЯам	ХУД-13	1	амины орон сууц	2	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/830
14	НБХБГазар	16	3	Орон сууц	11.465	ОССК, Хайлааст манхан ХХК	5	НЗД-ын А/191, А/855

1 5	НЕТГазар	3	1	үйлчилгээ орон сууц контор	0.2087	Компани ТББ	15	НЗД-ын 2015 оны А/822
1 6	НЗДТГ	10	9	Орон сууц	1.92	Мандан бадрах СӨХ	5	НЗД-ын А/978, А/830, А/205
1 7	НЗДТГ	10	1	Амины орон сууцны	40	Свифт хаус ХХК	5	НЗД-ын 2014 оны А/386
1 8	НЗДТГ	20	4	түрээсийн орон сууц	0.68	Компани ТББ	5	НЗД-ын А/205, /502, А/607
1 9	НЗДТГ	СБД-11	1	Хямд орон сууц	1.6	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/830
2 0	НЗДТГ	БГД 11 хороо	1	үйлчилгээ	0.06	Онгитур ХХК	5	НЗД-ын 2013 оны А/830
2 1	НЗДТГ	11	1	Төмс, тариалах	0.1	Б.Батцэнгэл	5	2014.04.04.
2 2	НЗДТГ	10	1	Үйлдвэрлэл	1	Рэс ХХК	2.5 жил	2014.11.10
2 3	НОБГ	ЧД 4-р хороо	1	Контор, орон сууц	0.64	Компани ТББ	5	2014.11.14
2 4	НӨХГ	11	2	Үйлчилгээтэй орон сууц	1.54	Бидний байшин НҮТББ	15	НЗД-ын 2015 оны А/937
2 5	СБДЗДТГ Цагдаагийн хэлтэс	СБД-11	1	Орон сууц	0.038	Компани ТББ	5	2012.06.22
2 6	СБДЗДТГ	8	3	Үйлчилгээ, орон сууц	0.086	Компани ТББ, иргэн	5	НЗД-ын А/205, А/830
2 7	Техник технологийн дээд сургууль	БГД 5 хороо	2	Ажилчдын орон сууц	0.5	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/830
2 8	Төрийн орон сууцны корпораци ТӨААТҮГ	12	6	Орон сууц	0.33	Бэрэн групп ХХК	5	НЗД-ын 2015 оны А/979
2 9	Төрийн өмчийн хороо	7	1	Орон сууц	0.24	Хамтын шийдэл ТББ	3	НЗД-ын 2016 оны А/247
3 0	УБДС ТӨХК	ХУД-3	1	Орон сууц	3	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/830
3 1	УСУГ	5	2	Орон сууц	0.53	Ус амин эрдэнэ НҮТББ	3 жил 10сар	НЗД-ын 2015 оны А/1000
3 2	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	10	39	Амины сууц	2.31	39 иргэнд	2 жил 6 сар	НЗД-ын 2015 оны А/53
3 3	Хил хамгаалах ерөнхий газар	БЗД-8	1	Орон сууцны хотхон	3.9	Компани ТББ	5	2012.04.18
3 4	Хилийн 0164 дүгээр анги	8	2	Орон сууц	9.28	Хилийн 0119-р анги	5	НЗД-ын 2013 оны А/752
3 5	ХУД-ийн Цагдаагийн хэлтэс	ХУД-1	1	Орон сууц	0.53	Компани ТББ	5	2012.06.22
3 6	ХУД-н ТҮК	ХУД-3	1	Орон сууц	0.052	Компани ТББ	5	2012.07.05

37	ХХЕГ, Хилийн 0119-р анги	7, 11	2	Орон сууцны орчны газар	3.9	Дархан хил СӨХ	5	НЗД-ын 2014 оны А/349
38	Цагдаагийн ерөнхий газар	11	10	орон сууц	1.79	Компани ТББ	5	НЗД-ын 2013 оны А/416
39	ЦЕГ-ын сургалтын төв	БГД 5 хороо	1	Ажилчдын орон сууц	0.2	Компани ТББ	5	НЗД-ын 2012 оны А/489
40	ЦЕГ-ын Эрүүгийн цагдаа	6, 20	2	Үйлчилгээтэй орон сууц	0.19	Ихмодун ХХК	5	НЗД-ын 2013 оны А/1050
41	ШУТИС	2	2	Орон сууц	0.57	ШУТИС-ийн хөгжлийн сан ТББ	5 жил 02 сар	НЗД-ын 2015 оны А/452
42	ШУА одон орон геофизикийн хүрээлэн	БЗД 5-р хороо	1	Контор, орон сууц	0.32	Компани ТББ	5	2014.11.16
НИЙТ ДҮН			123		105.1623			

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр газар эзэмших эрхэд өөрчлөлт оруулсан жагсаалт

Хавсралт №6

№	Өмнөх эзэмшигч, ашиглагч	Зориулалт	Байршил тоо	Хэмжээ /га/	Эрх шилжүүлж авсан эзэмшигч	Хугацаа / жил /	Захирамжийн огноо, дугаар
1	115-р цэцэрлэг	Сургалт	1	0.48	Цэцэрлэг	3 жил 10 сар	НЗД-ын 2015 оны А/379
2	Автозамын газар	Лаборатори	1	0.14	Авто замын хяналт, ЭШС төв	12 жил 4 сар	НЗД-ын 2014 оны А/920
3	БГД-ийн прокурорын газар	Контор	1	0.11	Дүүргийн 2 дугаар прокурорын газар	15	НЗД-ын 2014 оны А/349
4	БЗД-ийн Шавь цогцолбор	Сургалт	1	1.53	Сургууль	3 жил 10 сар	НЗД-ын 2015 оны А/379
5	Клиникийн 2-р нэгдсэн эмнэлэг	Орон сууц	1	0.51	Компани	3	НЗД-ын 2014 оны А/812
6	МУЭХолбоо	Үйлдвэрлэл	1	0.48	МУЭХолбоо	5	НЗД-ын 2013 оны А/416
7	МУЭХолбоо	Орон сууц	1	0.17	Блюдрагон ХХК	5	НЗД-ын 2013 оны А/416
8	НБГ	Сургалт	3	2.30	Сургууль цэцэрлэг	15	НЗД-ын 2013 А/1031, А/1050 2015 оны А/549
9	НЗДТГ	Орон сууц	4	40.75	Компани	5	НЗД-ын 2014 оны А/205, А/52, 2013 оны А/978
10	НЗДТГ	Сургалт	1	0.12	СХД усан спорт сургалтын төв	15	НЗД-ын 2014 оны А/52
11	НЗДТГ	Хороо, цогцолбор	1	0.07	БЗДЗДТГ	20	НЗД-ын 2015 оны А/561
12	НЗДТГ	Үйлдвэрлэл	1	160.0	Эмээлтийн ХҮҮ технологийн парк	15	НЗД-ын 2015 оны А/139

13	НЗДТГ	Сургалт	1	0.06	Цэцэрлэг	12 жил 04 сар	НЗД-ын 2014 оны А/646
14	Нийслэлийн 3 дугаар амаржих	Эмнэлэг	1	0.47	Энэрэл эмнэлэг УТУГ	7 жил 09 сар	НЗД-ын 2016 оны А/207
15	НБХГазар	Контор	1	7.00	Минж нутагшуулах үржүүлэх төслийн нэгж ОНӨААТҮГ	5	НЗД-ын 2014 оны А/52
16	Нийслэлийн БХБ-ын газар	Орон сууц	1	2.21	Компани	5	НЗД-ын 2013 оны А/855
17	Нийслэлийн БХБ-ын газар	Орон сууц	1	4.63	ОССК	5	НЗД-ын 2013 оны А/191
18	Нийслэлийн БХБ-ын газар	Үйлдвэрлэл	1	1.00	Компани	2 жил 6 сар	НЗД-ын 2014 оны А/947
19	Нийслэлийн БШУ-ны газар	Сургалт	1	0.40	Сургууль	9 жил 1 сар	НЗД-ын 2014 оны А/646
20	НӨХГ	үйлчилгээ	1	0.06	Компани	5	НЗД-ын 2012 оны А/455
21	НӨХГ	Орон сууц	1	0.77	Бидний байшин НҮТББ	15	НЗД-ын 2015 оны А/937
22	Нийслэлийн Соёл урлагийн газар	Контор	1	1.00	Соёлын өвийн төв	5	НЗД-ын 2013 оны А/191
23	Нийслэлийн цагдаагийн газар	Үйлчилгээ	3	0.01	БЗД, СХД, СБД-ийн цагдаа хэлтэс	5	НЗД-ын 2014 оны А/742
24	Нийслэлийн шүүх	Контор	1	0.28	Шүүхийн ерөнхий зөвлөл	5	НЗД-ын 2014 оны А/386
25	ОСНААУ Газрын 7 дугаар төв	Үйлчилгээ	1	0.02	ОСНААУГ, Эма Энд Би ХХК	5 жил	НЗД-ын 2016 оны А/207
26	СХД-ын замын цагдаагийн тасаг	Контор	1	0.14	СХД-ын цагдаа 3-р хэлтэс	8 жил 2 сар	НЗД-ын 2014 оны А/947
27	СБДЗДТГ	Орон сууц	1	0.02	Иргэн	5	НЗД-ын 2014 оны А/205
28	ТОССК	Орон сууц	6	0.33	Компани	5	НЗД-ын 2015 оны А/979
29	ТТАХ-ын нэгдсэн эмнэлэг	Контор	1	0.35	МУЕП газар	4 жил 1 сар	НЗД-ын 2014 оны А/742
30	УБХЗАА	Үйлдвэрлэл	1	1.00	Иргэн	5	НЗД-ын 2014 оны А/233
31	Ус сувгийн удирдах газар	Орон сууц	1	0.26	ТББ	3 жил 10сар	НЗД-ын 2015 оны А/1000
32	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	Амины сууц	39	2.31	39 иргэнд	2 жил 6 сар	НЗД-ын 2015 оны А/53
33	Хилийн 0164 дүгээр анги	Орон сууц	1	4.64	Хилийн 0119-р анги ТӨААТҮГ	5	НЗД-ын 2013 оны А/752
34	Хорих байгууллагуудын удирдах газар	Контор	1	0.27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар	15	НЗД-ын 2014 оны А/52
35	ХАХНХ-ын яам	Контор	1	0.05	ЧД-ийн Нийгмийн даатгалын хэлтэс	3 жил	НЗД-ын 2016 оны А/565
36	ХХЕГ, Хилийн 0119-р анги	Орон сууц	1	2.45	СӨХ	5	НЗД-ын 2014 оны А/349
37	Цагдаагийн Ерөнхий газар	Орон сууц	2	0.07	ТББ	5	НЗД-ын 2014 оны А/233
38	ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газар	Орон сууц	1	0.10	Компани	5	НЗД-ын 2013 оны А/1050
НИЙТ ДҮН			89	236.53			

Магадлан хэмжилт хийхэд 7 байршилд талбай давхацсан дүгнэлт.

Хавсралт №7

№	Дүгнэлтийн огноо дугаар	Дүүргийн нэр	Дүгнэлт
1	2017 оны 04 дүгээр сарын 28 өдрийн А/125 магадлан хэмжилтийн дүгнэлт	БГД	Барилгын коллежийн 10215 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэй бүртгэгдсэн боловч магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр 13283.9 м.кв талбай гарсан бөгөөд 3068.9 м.кв талбайг хэтрүүлж хашаа татаж эзэмшиж байна. Мөн нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн архивд бүртгэгдсэн нэгж талбарын 18641310488769 дугаар бүхий 800 м.кв талбайтай, регистрийн 2692058 дугаараар бүртгэгдсэн газартай 800 м.кв талбайгаар давхцалтай байна.
2		БГД	43-р сургуулийн зүүн талд байршилтай Баянгол дүүргийн Засаг даргын тамгийн газар /РД:9088822/-ийн эзэмшиж буй 1444 м.кв талбайтайгаар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна. Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнд 3 метрийн өргөнтэй зам нь 174.59 м.кв талбайгаар давхцаж байна.
3		БЗД	Улсын 2 дугаар төв эмнэлэг нь Засаг даргын 2014 А/704 тоот захирамжийн дагуу 46477 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна. Магадлан хэмжилт хийх ажлын хэсгийн үр дүнд "Чинбулаг" ХХК-ийн эзэмшиж буй газартай 571 м.кв талбайгаар давхцаж байна.
4		БЗД	Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэсэг Засаг даргын 2014 А/646 тоот захирамжийн дагуу 4193 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн байна. Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн үр дүнд орон сууцны газартай 178 м.кв талбайгаар давхцаж байна.
5		БЗД	Шинжлэх ухааны академийн одон орон, геофизикийн хүрээлэнгийн газар Засаг даргын 2017 А/90 тоот захирамжийн дагуу 1500 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн байна. Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнд Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18646311109477 дугаар бүхий 4500 м.кв талбайтай бүртгэгдсэн газартай 179 м.кв талбайтай, нэгж талбарын 18646311053469 дугаар бүхий 1879 м.кв талбайтай бүртгэгдсэн газартай 1856 м.кв талбайтай, нэгж талбарын 18646311017493 дугаар бүхий 701 м.кв талбайтай газартай 49 м.кв талбайтайгаар тус тус давхацсан байна.
6		БЗД	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төрийн үйлчилгээний газар Засаг даргын 2014 А/234 тоот захирамжийн дагуу 9732945 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна. Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн үр дүнд "Шинэ зуун айл зах" ХХК-ийн хашаалсан гэх хашаа нь 9860 м.кв талбайгаар давхцаж байна.
7		ЧД	Нийслэлийн тээврийн газар 2700 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэй бүртгэгджээ. Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээлэлтэй давхцуулж үзэхэд нэгж талбарын 18641314737372 дугаар бүхий 398 м.кв талбайтай газартай 62.06 м.кв талбайгаар, нэгж талбарын 18641314754406 дугаар бүхий 55.66 м.кв талбайтай газартай газартай 25.41 м.кв талбайгаар тус тус давхцалтай байна.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.5.4 дэх заалт, 18 дугаар зүйл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/112 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын хүсэлтийг үндэслэн Нийслэлийн засаг даргын захирамжаар төрийн байгууллагын хэрэгцээнд олгосон газарт магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ахлагч:	Б.Галмандах /Кадастрын хэлтсийн дарга
Гишүүд:	О.Дөлгөөнтуул /Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн/ Б.Урантөгс /Кадастрын хэлтсийн мэргэжилтэн/ Э.Эрдэнэбаатар /Кадастрын хэлтсийн мэргэжилтэн/ Э.Уранчимэг /"Геомэп" ХХК-ийн Кадастрын мэргэжилтэн/ Л.Доржнямбуу /"Геомэп" ХХК-ийн Геодезийн инженер/ Г.Билгүүн /"Геомэп" ХХК-ийн Геодезийн инженер/ Б.Баасандулам /"Геомэп" ХХК-ийн Геодезийн инженер/

2. Магадлан хэмжилтийн зардлын нэхэмжлэл болон магадлан хэмжилт хийсэн дүгнэлтийг түүнд холбогдох материалын хамтаар 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт хүргүүлэхийг Ажлын хэсэг /Б.Галмандах/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

08 00534

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн тоот албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР
МАГАДЛАН ХЭМЖИЛТ ХИЙСЭН ДҮГНЭЛТ

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот, Барилгачдын талбай 3, Засгийн газрын 12-р байр
Утас: 51-260785

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Б.Галмандах /Кадастрын хэлтсийн дарга/ О.Дөлгөөнтуул /Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн/, Б.Урантөгс /Кадастрын хэлтсийн мэргэжилтэн/, Э.Уранчимэг /"Геомэп" ХХК-ийн Кадастрын мэргэжилтэн/, Ш.Дугар /"Геомэп" ХХК-ийн Геодезийн мэргэжилтэн/, Л.Доржнямбуу /"Геомэп" ХХК-ийн Геодезийн мэргэжилтэн/ нар нь Үндэсний аудитын газрын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2/727 тоот албан бичгийг үндэслэн тус Газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/125 дугаар тушаалаар байгуулагдсан магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, дүгнэлт гаргав.

Магадлан хэмжилт хүлээн авсан: 2016 оны 04 дугаар сарын 20-ны өдөр

Магадлан хэмжилт дууссан: 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

ДҮГНЭЛТ:

Танай газраас ирүүлсэн албан бичгийн дагуу ГЗБГЗЗГ-ийн даргын 2017 оны 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/125 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаа. Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсэг нь Үндэсний аудитын газрын мэргэжилтний гаргаж өгсөн 11 байршилд 2017 оны 04 дүгээр сарын 25-аас 26-ны хооронд геодезийн нарийвчилсан хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ барилгажсан талбайд Topcon GTS 752 маркийн багажаар, өндөр барилга байгууламж байхгүй газарт хоёр долгионы GPS-н RTK горим/Observed Control Point/ бараж тоног, төхөөрөмжийг ашиглан WG1984 солбицлын тогтолцоо, UTM тусгагд гүйцэтгэсэн. Баянгол дүүргийн 5 байршил, Баянзүрх дүүргийн 4 байршил, Сонгинохайрхан дүүргийн 1 байршил, Чингэлтэй дүүргийн 1 байршил дараах дүгнэлтийг гаргалаа.

Магадлан хэмжилтийг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Баянгол дүүрэг

1.1 Баянгол дүүрэг, 17-р хороонд байршилтай “Барилгын коллеж” /РД:9089322/-д 2014 оны А/352 тоот захирамжаар олгогдсон газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны архивын мэдээлэлд нэгж талбарын 18641310515798 дугаар бүхий 10215 м.кв талбайтайгаар “Барилгын коллеж” /РД:9089322/-ийн нэр дээр газар эзэмших эрхтэй бүртгэгдсэн байна /Хавсралт 1/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр “Барилгын коллеж”-ийн одоо эзэмшиж буй газар нь 13283.9 м.кв талбайтай байна.

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн зурган мэдээллийг ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнтэй давхцуулан үзэхэд Баянгол дүүрэг, 17-р хорооны нутаг дэвсгэрт Барилгын коллеж РД:9089322/-д 2014 оны А/352 тоот захирамжаар 10215 м.кв талбайтайгаар олгогдсон газраас 3068.9 м.кв талбайг хэтрүүлж хашаа татаж эзэмшиж, ашиглаж байгаа болно. Мөн нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн архивд бүртгэгдсэн нэгж талбарын 18641310488769 дугаар бүхий 800 м.кв талбайтай, регистрийн 2692058 дугаараар бүртгэгдсэн газартай 800 м.кв талбайгаар давхцалтай байна /Хавсралт 2/.

1.2 Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд байршилтай Ган замын 20 дугаар сургууль /РД:9089829/ нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Засаг даргын 2016 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн А/128 тоот захирамжийн дагуу нэгж талбарын 18640310651497 дугаар бүхий 16366 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн байна /Хавсралт 3/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр Ган зам 20 дугаар сургуулийн одоо эзэмшиж буй газар нь 14573 м.кв талбайтай байна. Үүнээс 20 дугаар дунд сургуулийн эзэмшиж буй барилга 2839 м.кв талбайтай, 20 дугаар дунд сургуулийн биеийн тамирын талбай 1052 м.кв талбайтай, “Шинэ эрин” дунд сургуулийн барилга 1453 м.кв талбайтай, “Шинэ эрин” дунд сургуулийн эзэмшиж буй гэх биеийн тамирын талбай 717 м.кв талбайтай байна /Хавсралт 4/.

Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сантай давхцуулж үзэхэд Ган зам 20 дугаар сургууль нь Нийслэлийн Засаг

1011

даргын 2016 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн А/128 тоот захирамжаар олгогдсон 16366 м.кв талбайтай эзэмшиж буй газраа 1793 м.кв талбайгаар дутуу ашиглаж байгаа бөгөөд өөрийн эзэмшил газарт “Шинэ эрин” дунд сургуулийн эзэмшиж буй гэх 1453 м.кв талбайтай барилга, “Шинэ эрин” дунд сургуулийн эзэмшиж буй гэх биеийн тамирын 717 м.кв талбайтай талбайг “Шинэ эрин” дунд сургуульд эзэмшүүлж, ашиглуулж байна /Хавсралт 5/

1.3 Баянгол дүүргийн 2-р хороо, 2-р хороололд байршилтай Монгол оросын хамтарсан УБТЗ-ын газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээлэлд нэгж талбарын 18640310815804 дугаар бүхий 14212 м.кв талбайтайгаар УБТЗ-ын нэр дээр газар эзэмших эрхтэй бүртгэгджээ /Хавсралт 6/.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/246 дугаар захирамжаар Монгол оросын хамтарсан УБТЗ-д 14212 м.кв талбайтай газрыг эзэмшүүлсэн байх бөгөөд газар дээрээ газраа хашаалаагүй учир хэмжилт хийж хил заагийг тодорхойлох боломжгүй болно. УБТЗам нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээлэлд бүртгэгдсэн нэгж талбарын 18640310815804 дугаар бүхий 14212 м.кв талбайтай өөрийн эзэмшил газраа зүүн хойд талаараа газрын хил заагаас илүү гаргасан, зүүн урд талаараа дутуу хашаалан эзэмшиж байгаа бол өөрийн эзэмшил газарт ажилчдын орон сууц гэх 512 м.кв, 603 м.кв талбайтай барилгын газрыг эзэмшиж байна.

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээллийг ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнтэй давхцуулан хүргүүлэв /Хавсралт 7/.

1.4 Баянгол дүүрэг, 6-р хороо 10-р хороолол 43-р сургуулийн зүүн талд байршилтай Баянгол дүүргийн Засаг даргын тамгийн газар /РД:9088822/-ийн эзэмшиж буй газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18639310569894 дугаар бүхий 1444 м.кв талбайтайгаар Баянгол дүүргийн Засаг даргын тамга /РД:9088822/-ын газрын нэр дээр газар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна /Хавсралт 8/

Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээлэлтэй давхцуулж үзэхэд мэдээллийн сангийн архивын мэдээлэлд бүртгэгдсэн 1444 м.кв талбайтай /өөрийн эзэмшил/ газрын зүүн хойд булангаас 1.03 метр, баруун хойд булангаас 1.57 метрийг хэтрүүлэн

хашаагаа хойш татсан бол зүүн урд булангаас зүүн тийш 1.42 метр, баруун хойд булангаас баруун тийш 10.47 метр хэтрүүлэн хашаа татсан. Мөн тус эзэмшиж буй 1444 м.кв талбайтай газарт 3 метрийн өргөнтэй зам нь 174.59 м.кв талбайгаар давхцаж байна /Хавсралт 9/.

1.5 Баянгол дүүргийн 11 дүгээр хороонд байршилтай Монголын үндэсний олон нийтийн радио телевиз /МҮОНРТ/-ийн эзэмшиж буй ажилчдын орон сууцны барилга нь нийслэлийн Засаг даргын 2014 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/704 тоот захирамжийн дагуу нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18641312113106 дугаар бүхий 2924 м.кв талбайтай бүртгэгдсэн байна /Хавсралт 29/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр Монголын үндэсний олон нийтийн радио телевиз /МҮОНРТ/-ийн эзэмшиж буй гэх ажилчдын орон сууцны 346 м.кв, 789 м.кв талбай бүхий барилга, 196 метрийн урттай хашааг хэмжилт хийн гүйцэтгэсэн.

МҮОНРТ-ийн одоо эзэмшиж буй хашааны талбайн хэмжээг газар дээр нь тэмдэгжүүлсэн эргэлтийн цэг, хашаалсан хашаа байхгүй учир талбайн хэмжээг тодорхойлох боломжгүй болно /Хавсралт 30/.

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18641312113106 дугаар бүхий 2924 м.кв талбайтай бүртгэгдсэн МҮОНРТ-ийн эзэмшиж буй газрыг ажлын хэсгийн хэмжилтийн дүнтэй давхцуулахад дээрх орон сууцны барилгууд нь МҮОНРТ-ийн эзэмшлийн газартаа хамаарагдаж байгаа бөгөөд МҮОНРТ-ийн хашаалсан гэх хашаа нь 43 м.кв талбайгаар дутуу хашаалсан болно /Хавсралт 31/.

2. Баянзүрх дүүрэг

2.1 Баянзүрх дүүргийн 3 дугаар хороонд байршилтай Улсын 2 дугаар төв эмнэлэг нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Засаг даргын 2014 оны 08 дүгээр сарын 14-ний өдрийн А/704 тоот захирамжийн дагуу нэгж талбарын 18644311787382 дугаар бүхий 46477 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна /Хавсралт 10/.

Магадлан хэмжилт хийх ажлын хэсэг нь Улсын 2 дугаар төв эмнэлгийн эзэмшиж буй гэх 706 м.кв талбайтай барилга, орон сууцны 1026 м.кв, 1007 м.кв талбайтай барилга, 74 м.кв талбайтай ТП, хашаа /урт 154 метр/-г тус тус хэмжилт хийн гүйцэтгэлээ /Хавсралт 11-12/.

1017

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн зурган мэдээллийг ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнтэй давхцуулахад Улсын 2 дугаар төв эмнэлгийн эзэмшиж буй 46477 талбайтай газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18644311764508 дугаар бүхий 5100 м кв талбайтай бүртгэгдсэн "Чинбулаг" ХХК-ийн эзэмшиж буй газартай 571 м кв талбайгаар давхцаж байна /Хавсралт 13-14/.

2.2 Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороонд байршилтай Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэсэг нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Засаг даргын 2014 оны 07 дугаар сарын 25-ний өдрийн А/646 тоот захирамжийн дагуу нэгж талбарын 18645311857919 дугаар бүхий 4193 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн байна /Хавсралт 15/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн үр дүнгээр орон сууцны 1035 м.кв талбайтай барилгын газрыг хэмжилт хийн зураглалаа /Хавсралт 16/.

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн зурган мэдээллийг ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнтэй давхцуулахад дээрх орон сууцны 1035 м.кв талбайтай барилгын газар нь Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэсгийн эзэмшиж буй 4193 м.кв талбайтай газартай 178 м.кв талбайгаар давхцаж байна /Хавсралт 17/.

2.3 Баянзүрх дүүргийн 5 дугаар хороонд байршилтай Шинжлэх ухааны академийн одон орон, геофизикийн хүрээлэнгийн газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/90 тоот захирамжийн дагуу нэгж талбарын 18646311054515 дугаар бүхий 1500 м.кв талбайтайгаар бүртгэгдсэн байна /Хавсралт 18/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр Шинжлэх ухааны академийн одон орон, геофизикийн хүрээлэнгийн одоо эзэмшиж буй газар нь 4137 м.кв талбайтай байна /Хавсралт 19/.

Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн зурган мэдээлэлтэй Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг давхцуулахад Шинжлэх ухааны академийн одон орон, геофизикийн хүрээлэнгийн одоо эзэмшиж буй 4137 м.кв талбайтай газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарын 18646311109477 дугаар бүхий 4500 м.кв талбайтай бүртгэгдсэн газартай 179 м.кв талбайтай, нэгж талбарын 18646311053469 дугаар бүхий 1879 м.кв талбайтай бүртгэгдсэн газартай

1856 м.кв талбайтай, нэгж талбарын 18646311017493 дугаар бүхий 701 м.кв талбайтай газартай 49 м.кв талбайтайгаар тус тус давхцсан байна /Хавсралт 20/

2.4 Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байршилтай Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төрийн үйлчилгээний газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/234 тоот захирамжийн дагуу нэгж талбарын 18648308323693 дугаар бүхий 9732945 м.кв талбайтайгаар газар эзэмших эрхтэйгээр бүртгэгдсэн байна /Хавсралт 21/.

Магадлан хэмжилт хийх үүрэг бүхий ажлын хэсэг нь 2826 метрийн урттай 14.6 метрийн өргөнтэй авто зам, 2208 метрийн урттай, 3.0 метрийн өргөнтэй явган хүний зам болон "Шинэ зуун айл зах" ХХК-ийн эзэмшиж буй гэх 672 метрийн урттай хашааг хэмжилт хийн гүйцэтгэсэн /Хавсралт 22-23/.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төрийн үйлчилгээний газрын эзэмшиж буй 9732945 м.кв талбайтай газартай Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүн болох 2826 метрийн урттай, 14.6 метрийн өргөнтэй авто зам, 2208 метрийн урттай, 3.0 метрийн өргөнтэй явган хүний зам болон "Шинэ зуун айл зах" ХХК-ийн хашаалсан гэх хашаа нь 9860 м.кв талбайгаар тус тус давхцаж байна /Хавсралт 24/.

3. Чингэлтэй дүүрэг

3.1 Чингэлтэй дүүрэг 12-р хороонд байршилтай Нийслэлийн тээврийн газар /РД:2117428/ нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээлэлд нэгж талбарын 18641314729415 дугаар бүхий 2700 м.кв талбайтайгаар Нийслэлийн тээврийн газрын нэр дээр газар эзэмших эрхтэй бүртгэгджээ /Хавсралт 25/.

Нийслэлийн тээврийн газар нь нийслэлийн Засаг даргын 2008 оны А/397 дүгээр захирамжаар эзэмшүүлсэн 2700 м.кв талбайтай газраа газар дээрээ тэмдэгжүүлэн газарт бэхэлсэн эргэлтийн цэг болон хашаалаагүй тул хэмжилт хийн хил зааг тодорхойлж талбайн хэмжээ тодорхойлох боломжгүй болно.

Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээлэлтэй давхцуулж үзэхэд нэгж талбарын 18641314737372 дугаар бүхий 398 м.кв талбайтай газартай 62.06 м.кв талбайгаар,

нэгж талбарын 18641314754406 дугаар бүхий 55.66 м.кв талбайтай газартай газартай 25.41 м.кв талбайгаар тус тус давхцалтай байна /Хавсралт 26/





4. Сонгинохайрхан дүүрэг

4.1 Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороонд байршилтай Өнөр Энх Өргөө ОНӨААТҮГ /5652413/-ийн газар нь нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны мэдээлэлд нэгж талбарын 18637310601534 дугаар бүхий 3500 м.кв талбайтай газар эзэмших эрхтэй бүртгэгдсэн байна /Хавсралт 27/.

Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнгээр Өнөр Энх Өргөө ОНӨААТҮГ-ийн одоо эзэмшиж буй газар нь 2336.4 м.кв талбайтай байна.

Ажлын хэсгийн хэмжилтийн үр дүнг нийслэлийн газрын кадастрын мэдээллийн сангийн 2017 оны зурган мэдээлэлтэй давхцуулан хүргүүлэв /Хавсралт 28/

Дүгнэлт гаргасан:

	Б.Галмандах
	О.Дөлгөөнтуул
	Б.Урантөгс
	Э.Уранчимэг
	Ш.Дугар
	Л.Доржнямбуу



2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн газрын албанаас төрийн байгууллагын хэрэгцээнд олгосон газар олголт хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэхэд хийсэн эрсдэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Газрын алба, Нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ц.Сандуй/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга /Ц.Ганхүү/, Нийслэлийн Газрын албаны дарга /Э.Болорчулуун/, Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд газрын дарга /Э.Анар/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газар /Б.Алтанзул/-т даалгасугай.

5. Аудитын тайлан, ажлын баримт, нотлох зүйлийг зохих журам, зааврын дагуу архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газрын захирал /Б.Алтанзул/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР